



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 05. 09

№

435

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч иргэн Хүрэлбаатар овогтой Сувдаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Хүрэлбаатар овогтой Сувдаагийн Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Х.Сувдаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг Баянгол дүүргийн Сонгуулийн хороонд.

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ